

“ТӨМӨР ЗАМЫН ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ, НОРМ, СТАНДАРТЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ” ТӨСӨЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам /цаашид “Сан” гэх/-ийн ажиллах журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Сангийн удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах ажлыг Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар” буюу цаашид “Агентлаг” гэх) хариуцан зохион байгуулна.

1.3.Сангийн хөрөнгөөр төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад салбарын эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, төмөр замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажил, зөвлөх үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэдийг оролцуулах зарчмыг баримтална.

1.4.Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, сурталчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу агентлаг зохион байгуулна. Сан нь агентлагийн тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

1.5.Сангийн орлогыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн сан дахь бүртгэлийн дансанд энэ журмын 3.2-т заасан хугацаанд төвлөрүүлнэ.

1.6.Сангийн хөрөнгийн орлого, зарлагын баримтад агентлагийн дарга нэгдүгээр, ерөнхий нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж, баталгаажуулна.

1.7.Сангийн хөрөнгийн зарцуулалттай холбогдсон анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь агентлагийн нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, хянуулах, батлуулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах сангийн үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий Сангийн удирдах

зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хянах Хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ тус тус ажиллана.

2.2. Удирдах зөвлөл нь 9, Хяналтын зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байна. Гишүүдийг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, төмөр замын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулна. Удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүн нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалтын шаардлагыг хангасан байна.

2.3. Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хянан хэлэлцэж батлах;

2.3.2. Тухайн жилд боловсруулах төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын судалгааны ажлын жагсаалт, нэр төрөл, тэдгээрийг боловсруулах, хэвлүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг батлах;

2.3.3. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын боловсруулалтын ажлын явц, тайланг хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээг авах;

2.3.4. Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналтын тайланг хэлэлцэн дүгнэх.

2.4. Удирдах зөвлөл нь сангийн тухайн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэж, ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор хэлэлцэж, батална.

2.5. Удирдах зөвлөлийн хурал бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

2.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл хөтөлж, түүнийг удирдах зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.7. Удирдах зөвлөлийн дарга нь төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төмөр замын бодлого зохицуулалтын газрын дарга, дэд дарга нь агентлагийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд дэд дарга ажил үүргийг орлон гүйцэтгэнэ.

2.8. Удирдах зөвлөлийн дарга нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.8.1. Удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийг томилуулах, өөрчлөх, гишүүдэд олгох цалин, урамшууллыг тогтоох талаар санал боловсруулж, төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.8.2. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах дарааллыг тогтоох санал оруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2.8.3. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлж, батлуулах;

2.8.4. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зориулалт, зарцуулалтын талаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгуулах.

2.9. Сангийн хяналтын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.9.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.9.2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих.

2.10. Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын бичиг, үнэ бүрдэлтийг боловсронгуй болгож, шинжлэх ухааны ололт, шинэ техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.10.2. Төмөр зам, замын байгууламж барих, засварлах, арчлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналттай холбоотой норм, норматив, техникийн баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих.

2.11. Агентлаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.11.1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.2, 10.2.7, 10.2.8, 10.2.10, 10.2.15 дахь заалтууд болон энэ журамд заасны дагуу удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөө, шийдвэрийг үндэслэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.11.2. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх;

2.11.3. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын бичгийг боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үндсэн чиглэл, хөтөлбөр боловсруулах, гадаад орны туршлагыг судлан шаардлагатай стандарт, норм, техникийн баримт бичгийг худалдан авах;

2.11.4. Төмөр зам, замын байгууламжийн стандарт, норм, техникийн баримт бичгийн төсөлд мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус хүн, хуулийн этгээдээр шүүмж, редакц хийлгэх, санал, дүгнэлт гаргуулах;

2.11.5. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг бэлтгэж, хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.11.6. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын бичгийг боловсруулах, хэвлэн олшруулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн цахим сан байгуулж, тогтмол баяжуулах ажлыг зохион байгуулах;

2.11.7. Батлагдсан төлөвлөгөөний дагуу төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, програм болон техник хангамж, тоног төхөөрөмж, техникийн баримт бичиг, материал худалдан авах.

2.11.8. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр туршлага судлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, төмөр замын тээврийн салбарт шинжлэх ухаан технологи, инновацыг нэвтрүүлэх төлөвлөгөө, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

2.11.9. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын эх материал болон төсөлд шүүмж, редакц хийлгэсэн санал, дүгнэлт, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан холбогдох материалыг архивын нэгж болгон хадгалах;

2.11.10 Төмөр замын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ дэвшилтэт техник технологи, холбогдох баримт бичиг, норм, стандартыг судлах зорилготой гадаад, дотоодын хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт мэргэжлийн байгууллага, ажилтнуудыг хамруулах асуудлыг сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

Гурав. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

3.1. Сангийн хөрөнгө нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Хүн, хуулийн этгээд нь тухайн жилд гүйцэтгэх төмөр замын суурь бүтцийг барих, өргөтгөх, шинэчлэх, зураг төсөл боловсруулах ажлын төсөвт өртгөөс 0.4 хувиар тооцож, санхүүжилтийн эрх нээгдсэнээс хойш ажлын 14 хоногт багтаан сангийн дансанд төвлөрүүлнэ.

3.3. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандарт борлуулсны орлого болон төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандивыг тухай бүрт нь сангийн дансанд төвлөрүүлнэ.

3.4. Санд хөрөнгө төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн хүн, хуулийн этгээдийн төлбөрийг санд нөхөн төвлөрүүлэх ажлыг агентлаг зохион байгуулж, уг орлогыг хугацаандаа төвлөрүүлээгүй тохиолдолд 0.05 хувийн алдангийг нэмж тооцно.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна:

4.1.1. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, шүүлт, үзлэг хийх, редакц, шүүмж хийлгэх, эмхэтгэн хэвлүүлэх, сурталчлах зардал;

4.1.2. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсруулахад шаардлагатай ном хэвлэл, аргачлал, заавар, олон улс, бүс нутаг, гадаад орны төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандарт, материал худалдан авах зардал;

4.1.3. Олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл, хамтын ажиллагааны зардал;

4.1.4. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгохтой холбоотой хурал, зөвлөгөөн, сургалт, семинарт холбогдох ажилтнуудыг оролцуулах, тэдгээрийг зохион байгуулах, зардал;

4.1.5. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартыг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд шаардагдах зардал;

4.1.6. Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын судалгааны ажлын тайлангийн төслийг төмөр зам, далайн тээврийн салбарын шинжлэх ухаан технологийн дэд зөвлөл, Зам, тээврийн хөгжлийн яамны шинжлэх ухаан технологийн зөвлөл, Стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх зардал;

4.1.7. Монгол Улсын төмөр замын сүлжээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг үүсгэх, баяжуулах, шинэчлэх, шаардлагатай програм болон техник хангамж, тоног төхөөрөмж худалдан авах зардал;

4.1.8. Сангийн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын зардал;

4.1.9. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах зардал;

4.2. Сангийн хөрөнгийг Төмөр замын тээврийн тухай хууль болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах

5.1. Агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын эхний хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон удирдах зөвлөлд тайлагнана.

5.2. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон агентлагийн вэб сайтад байршуулж, түүний хэрэгжилтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3. Хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад жилд нэгээс доошгүй удаа хяналт, шинжилгээ хийж, тайланг удирдах зөвлөлд танилцуулна.

Зургаа. Хариуцлага

6.1 Энэхүү журмыг зөрчигсдөд Монгол улсын Төмөр замын тээврийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны.....дугаар сарын ... -ны
өдрийн дугаар тушаалын
хавсралт

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга
Дэд дарга:	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар”-ын дарга
Нарийн бичгийн дарга:	Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр замын бодлого зохицуулалтын газрын шинжээч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар”-ын Суурь бүтцийн газрын дарга Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Төмөр замын газар”-ын Инженер техникийн газрын дарга Төмөр замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

САНГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Гишүүд:	Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газрын дарга Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Санхүүгийн хяналт шалгалт хариуцсан /Төмөр зам, далай, усан замын тээврийн бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан/ ахлах шинжээч Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Төмөр замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)